



**“ЖУУЛЧИН ДЮТИ ФРИЙ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2022 оны 03 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар ТУЗ2022-03/02

Улаанбаатар
хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дугаар зүйлийн 59.1, 59.4, 59.10, 59.11, 60 дугаар зүйл, 62 дугаар зүйл, 64 дүгээр зүйл, 65 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Жуулчин Дюти Фрий ХК-ийн дүрмийн 7-р зүйлийн 7.1, 7.2, 7.3 дах хэсэг, 8-р зүйлийн 8.9.3 дэх хэсгийг тус тус үндэслэн ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС ТОГТООХ нь:

1. “Жуулчин Дюти Фрий” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2022 оны 04-р сарын 27-ны өдрийн Лхагва гарагийн 10:00 цагт Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Чингисийн өргөн чөлөө, “Таван Богд Групп”-ийн төв байрны, 2,5-р давхарт байрлах хурлын танхимд хуралдуулахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлэхээр баталсугай. Үүнд:

- 2.1 Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан танилцуулах,
- 2.2 Төлөөлөн удирдах зөвлөлөөс санхүүгийн тайланд хийсэн дүгнэлтийг хэлэлцэн, батлах
- 2.3 Компанийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компанийн дүгнэлтийг танилцуулах,
- 2.4 Компанийн 2021 оны ногдол ашгийн тухай гаргасан ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах,
- 2.5 Компанийн 2022 оны санхүүгийн төлөвлөгөө, зардлын төсвийг танилцуулах, батлах

3. Санхүүгийн зохицуулах хорооны журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг Хавсралт №1-ээр баталж, 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн дотор багтаан Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид хүргүүлэхийг тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг хавсралт №2-оор баталж 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Монголын хөрөнгийн бирж, болон өөрийн цахим хуудас, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сониноор дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, мөн 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр анх мэдээлсний дагуу дахин хурлын зарыг хүргэхээр тогтоосугай.

5. Хурлаар хэлэлцэх асуудал, түүнтэй холбогдох баримт бичигтэй ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ /Утас: 95958708, Baterdene.b@tavanbogd.com/ --тай холбогдон танилцах боломжтойг болохыг мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбоотой бичиг баримтыг 2022 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн дотор багтаан хувьцаа эзэмшигчдэд болон тэдгээрт үйлчилж буй брокер, дилерийн компанид хүргүүлсүгэй.

7. Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2022 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр байхаар тогтоосугай.

8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд биечлэн оролцох боломжгүй, саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацааг 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 17:00 цаг хүртэл тогтоосугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар О.Доржхандыг томилсугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Д.Оргил, гишүүдээр Ж.Түвшинтуул, Т.Жамсран нарыг тус тус томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн хурал зохион байгуулах комиссын даргаар Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаярыг томилон, хурал зохион байгуулахтай холбоотой зардлыг компаниас гаргахыг зөвшөөрсүгэй

12. Хувьцаа эзэмшигчдийг хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж, хуралд бэлтгэх, хурал зохион байгуулах бэлтгэх ажлыг ханган ажиллахыг Хурлын дарга О.Доржханд, хурал зохион байгуулах комиссын дарга Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Ц.Отгонбаяр, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Б.Бат-Эрдэнэ нарт даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА  Ц.БААТАРСАЙХАН

